



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл, Урлагийн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “2019 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 684,496,560.00 (зургаан зуун наян дөрвөн сая дөрвөн зуун ерэн зургаан мянга таван зуун жаран) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Соёл, Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

000015

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
.....43..... дугаар тогтоолын хавсралт



Соёл Урлагийн Их Сургуулийн 2019 онд хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
		(төгрөг)
Барилгын зураг төсөв		
1	Барилгын ажлын зураг төсөв / РТМУС-ын өргөтгөл барих /	20,000,000.00
2	Барилгын ажлын зураг төсөв /Оюутны дотуур байр шинээр барих/	110,000,000.00
Бүгд дүн		130,000,000.00
Хөгжим, хэрэгсэл		
3	Ятга/Дунд гарын/	650,000.00
4	Шанз	9,000,000.00
5	Төгөлдөр хуур	15,140,000.00
6	Монгол ёочин	1,620,000.00
7	Морин хуур (ширэн цартай)	10,000,000.00
8	Цахилгаан даралтат хөгжим	4,347,780.00
9	Цахилгаан хөгжмийн чадлын өсгөгч	850,000.00
10	Цахилгаан хөгжмийн яригч	3,200,000.00
11	Цахилгаан хөгжмийн пульт	650,000.00
12	Цахилгаан хөгжмийн микрофон	264,000.00
Бүгд дүн		45,721,780.00
	Биет бус хөрөнгө	
13	Удирдлагын программ - Динамик оффис	23,000,000.00
Бүгд дүн		
14	Тоног, төхөөрөмжийн дүн	239,770,080.00
15	Тавилга эд хогшлын дүн	162,688,700.00
16	Номын фондын баяжилтын дүн	83,316,000.00
		684,496,560.00
НИЙТ ДҮН		(зургаан зуун наян дөрвөн сая дөрвөн зуун ерэн зургаан мянга таван зуун жаран)